

**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН
НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН
ТӨСЛҮҮДИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2024 оны 05 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасны дагуу нэн яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Нийгмийн бодлогын байнгын хороо 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч олон улсын стандартын шаардлага хангасан эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, худалдах, түгээх, хэрэглэх, хянах үйл ажиллагаанд орчин үеийн технологи болон зохистой дадлыг бүрэн нэвтрүүлэх, тэдгээрийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд өргөнөөр ашиглаж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, нийлүүлэлт, засвар үйлчилгээ, ханган нийлүүлэхтэй холбогдсон харилцааг цогцоор нь зохицуулахаар хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар эм, биобэлдмэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалтыг хэрэгжүүлэгч талуудын чиг үүрэг, чанар, аюулгүй байдлын зохицуулалт боловсронгуй болж, эм, эмнэлгийн хэрэгслийн үнийн хөөрөгдөл, иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахтай холбогдсон санхүүгийн эрсдэл буурч, эмнэлгийн хэрэгсэл, тухайлбал тоног төхөөрөмжийн бүртгэл, нэршил, ангилал, чанар, аюулгүй байдал, шалгалт баталгаажуулалт, шалгалт тохируулга, хөрөнгийн төлөвлөлт, мэдээллийн сан, засвар үйлчилгээний менежментийн тогтолцоог зохицуулах боломж бүрдэж, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангахад төрийн чиг үүрэг, хариуцлага нэмэгдэж, уламжлалт эмийн зохицуулалт боловсронгуй болж, эм, биобэлдмэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалт олон улсын жишигт хүрэх ба хуулийн этгээдэд хүлээсэн тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд хүний нөөцийг нэмэгдүүлэх шаардлагатай бөгөөд түүнд ойролцоогоор 2,9 сая төгрөгийн зардал бий болохоор, мөн хуулийн төсөл батлагдсаны дараа гарах эрх зүйн баримт бичгийг боловсруулах, олон улсын байгууллагатай хамтран ажиллах, судалгаа хийхэд нэмэлт зардал гарч болзошгүй гэж төсөл санаачлагч үзсэн байна.

Хуулийн төслийг d.parliament.mn цахим хуудаст байршуулан иргэд, олон нийтийн санал авч байгаа болно.


Хуулийн төслийг хэлэлцэх үед Байнгын хорооны гишүүдээс асуулт, санал гараагүй бөгөөд Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 77.8 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



П.АНУЖИН